BDSec Securities

# УЛААНБААТАР БОНД

2023 ОН

# Улаанбаатар бонд

## Үнэт цаас гаргах зөвшөөрөл, шийдвэр

БиДиСЕК ХК

### Сангийн яамны дүгнэлт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**2023/07/17**

№01/5287
Албан бичиг

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор 500 тэрбум төгрөг хүртэлх хэмжээний үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргахад татгалзах зүйлгүй байна.

### Монгол Улсын Засгийн Газар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**2023/07/19**

№282 тогтоол

Нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргаж, үе шаттайгаар арилжаалах зөвшөөрөл олгосон.

### Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

**2023/08/09**

№97 тогтоол

Нийслэлийн үнэт цаас гаргаж, арилжихыг дэмжиж, үнэт цаасны ерөнхий нөхцөлийг баталсан.

### Санхүүгийн Зохицуулах Хороо

**2023/09/01**

№427 тогтоол

Санхүүгийн зохицуулах хороо нийслэлийн үнэт цаасыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэв.




# 1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

# Макро эдийн засгийн тойм

БиДиСЕК ХК

## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт*
52 их наяд төгрөг | 4.8%
2022 оны жилийн эцсийн байдлаар

Нэг хүнд ноогдох ДНБ
15.8 сая төгрөг
2022 оны жилийн эцсийн байдлаар

Бодлогын хүү
13%

Инфляци
9.2%
2023 оны 07 сарын байдлаар

Долларын ханш
3,470₮
2023.08.16-ний байдлаар

Гадаадын шууд хөрөнгө оруулалт
27 тэрбум ам.доллар
2022.09.30-ны байдлаар

Төсвийн тэнцэл
1.5 их наяд төгрөг
2023.06.30-ны байдлаар

Гадаад өр
33.6 тэрбум ам.доллар
2023.06.30-ны байдлаар

## ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

B3/Stable — Moody's

B/Stable — S&P Global Ratings

B/Stable — FitchRatings

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023.06.30-ны өдрийн байдлаар

Банкны актив
48 их наяд төгрөг

Гадаад валютын нөөц
3.8 тэрбум ам.доллар

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ
10.5 их наяд төгрөг

## ГАДААД ХУДАЛДАА

2023.06.30-ны өдрийн байдлаар

Гадаад худалдааны тэнцэл
3.2 тэрбум ам.доллар

Импорт
4.2 тэрбум ам.доллар

Экспорт
7.5 тэрбум ам.доллар

# Макро эдийн засгийн тойм

## Дотоодын нийт бүтээгдэхүүн
Их наяд төгрөг




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ОУВС**

## Инфляц, бодлогын хүү
Хувиар




*Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо*

## Экспорт
Тэрбум ам.доллар




*Эх сурвалж:, Үндэсний статистикийн хороо*

## Нүүрс, зэсийн баяжмалын экспорт
Сая.тн




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

# Макро эдийн засгийн тойм

Улсын нэгдсэн төсвийн орлого
Их наяд төгрөг




*Эх сурвалж:, Үндэсний статистикийн хороо*

Улсын нэгдсэн төсвийн зарлага
Их наяд төгрөг




*Эх сурвалж:, Үндэсний статистикийн хороо*

Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын 48.9 хувь оршин суудаг, дотоодын нийт бүтээгдэхүүний 64.1 хувийг эзэлдэг. Гэвч Улаанбаатар хотын төсөв улсын төсвийн 10 гаруй хувийг эзэлж байгаа нь Нийслэлд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд хүрэлцэхгүй байна.



# 2 Нийслэлийн тухай

# Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот

Танилцуулга

БиДиСЕК ХК

Улаанбаатар Иргэн төвтэй хот

Нийт хүн амын

**48.9%** буюу **1,691,766 иргэн**

Газар нутгийн

**0.3%** буюу **4,704.4 км2**

Дотоодын нийт бүтээгдэхүүний

**64.1%** буюу **33.9 их наяд**

Улсын нэгдсэн төсвийн

**13%** буюу **1.9 их наяд**

## ЭРХЭМ ЗОРИЛГО

✓ Иргэд, оршин суугчдынхаа амьдралын чанарыг дэмжсэн ухаалаг бодлого, оновчтой зохицуулалт, хүлээлтэд нийцсэн үйлчилгээг харилцагч талууддаа үзүүлэх.

Нийслэлийн хэмжээнд нийт **9** дүүрэг

Нийт **33** хэрэгжүүлэгч агентлаг

Нийт **13** харьяа байгууллагууд

# УЛААНБААТАР бонд

Тулгамдаж буй асуудлууд

**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ**

1 км замыг туулж өнгөрөх дундаж хугацаа
**10 минут**

Цэцэрлэг
**46%**
**649/1,413**

Тээврийн хэрэгсэл
**56%**
**712,992/1,264,892**

Сургууль
**34%**
**293/859**

Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо /2-5 нас/
**69%**
**127,278/184,756**

Агаарын бохирдол
**Стандартаас 1.5 дахин их**

ЕБС-ын сурагчдын тоо
**49%**
**363,377/746,405**

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

# Улаанбаатар бонд

Нийслэлийн төсвийн мэдээлэл

## Нийслэлийн орлого

тэрбум ₮




## Нийслэлийн орлогын бүтэц




## Нийслэлийн зардал

тэрбум ₮




## Нийслэлийн зардлын бүтэц




**Боловсролын сайдын багц буюу сургууль, цэцэрлэгт зориулсан зардлыг төсвийн орлогод тооцдоггүй бөгөөд **тусгай зориулалтын шилжүүлэг** хэмээн төрийн сангийн дансаар дамжуулан шилжүүлдэг.*

*Эх сурвалж: https://irged.ulaanbaatar.mn/, 2022 оны нийслэлийн төсөв*

# Улаанбаатар бонд

Санхүүгийн төсөөлөл

Төсвийн тухай хуулийн 57.2-т заасны дагуу **Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.**

| /тэрбум төгрөг/ | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
|---|---|---|---|---|---|
| Нийслэлийн орлого | 1,688.7 | 1,781.2 | 1,871.5 | 1,982.0 | 2,099.1 |
| Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар | 726.0 | 769.5 | 815.7 | 864.6 | 916.5 |
| ААНОАТ | 267.5 | 283.5 | 300.5 | 318.6 | 337.7 |
| Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар | 132.1 | 140.1 | 148.4 | 157.3 | 166.8 |
| Газрын төлбөр | 106.7 | 113.1 | 119.9 | 127.1 | 134.7 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 93.9 | 99.6 | 105.6 | 111.9 | 118.6 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 57.8 | 61.3 | 65.0 | 68.9 | 73.1 |
| АТӨЯХАТ | 39.9 | 42.3 | 44.8 | 47.5 | 50.4 |
| Хувь хүний орлогын албан татвар | 28.1 | 29.8 | 31.6 | 33.5 | 35.5 |
| Бусад | 236.3 | 241.6 | 239.6 | 252.2 | 265.5 |
| Нийслэлийн төсвийн урсгал зардлын дүн | 868.7 | 877.3 | 886.1 | 912.0 | 921.3 |
| УБ хотын урсгал зардал | 499.5 | 504.4 | 509.5 | 524.4 | 529.7 |
| Дүүргийн урсгал зардал | 369.2 | 372.8 | 376.6 | 387.6 | 391.5 |
| Нийслэлийн төсвийн хөрөнгийн зардлын дүн | * | * | * | * | * |

*Нийслэлийн төсвийн хөрөнгийн зардлыг нийслэлийн орлогоос илүү гарсан дүнг харгалзан Сангийн яамтай харилцан тохиролцон тухай бүр шийдвэрлэдэг.

# Улаанбаатар бонд

Хөтөлбөрийн эхний үе шат-Үнэт цаасны нөхцөл

| | |
|---|---|
| Үнэт цаасны нэр | Улаанбаатар бонд |
| Үнэт цаасны арилжаа | Олон нийтэд нээлттэй |
| Татан төвлөрүүлэх дүн | 277,863,500,000 төгрөг |
| Үнэт цаасны нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг | 2,778,635 ширхэг |
| Үнэт цаасны хугацаа | 24 сар |
| Үнэт цаасны хүү | 17.2% |
| Хүү (купон) төлөх давтамж | Хагас жил тутам |
| Үндсэн төлбөр төлөх хугацаа | Хугацааны эцэст |
| Бондын зарцуулалт | Улаанбаатар бондыг дараах төсөл хөтөлбөрүүдэд зарцуулна. Үүнд:<br>– 62.8 тэрбум төгрөг – Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх<br>– 150 тэрбум төгрөг – “Сэлбэ сэргэлт” төсөл<br>– 31.9 тэрбум төгрөг – Агаарын бохирдлыг бууруулах<br>– 28.8 тэрбум төгрөг – Дэд бүтцийг сайжруулах |



# СЭЛБЭ СЭРГЭЛТ

## Зарцуулах дүн

**150.0** тэрбум төгрөг хүртэл

Сэлбэ, Дунд голын дагуу үерийн гамшгаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй Сэлбэ сэргэлт төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын санхүүжилтэд зарцуулна.

**Сонсголонгийн зам**

**Дамбадаржаа цэцэрлэгт хүрээлэн**

# Улаанбаатар бонд

Зарцуулалт болон үр дүн

БиДиСЕК ХК

### СЭЛБЭ ГОЛ

**Сэлбэ гол**

**9 км** далан **70%** ил задгай урсдаг

**Сэлбэ голын тэжээл**

**69%** хур борооны ус **5%** цас **26%** ул хөрсний ус

*Эх сурвалж: Сэлбэ сэргэлт төсөл*

### ТӨСЛИЙН ҮР ДҮН

**Авто зам**

**21.6 км**

**Явган болон унадаг дугуйн зам**

**43.2 км**

**Нийтийн тээврийн зогсоол**

**68**

**Гүүр**

**18** Туслах гүүр **4** Гүүрэн байгууламж



# ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОВСРОЛ

## Зарцуулах дүн

**100.0** тэрбум төгрөг хүртэл

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулна.

# Улаанбаатар бонд

Зарцуулалт болон үр дүн

БиДиСЕК ХК

**2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД**

| Ерөнхий боловсрол | Сургуулийн өмнөх боловсрол | Сургууль, цэцэрлэгийн тоо |
|---|---|---|
| **364** мянган хүүхэд | **127** мянган хүүхэд | **293** сургууль **639** цэцэрлэг |

*Эх сурвалж: Боловсрол шинжлэх ухааны яам*

**ТӨСЛИЙН ҮР ДҮН**

**Цэцэрлэг**

**8** цэцэрлэг **3** өргөтгөл **2,220** ор

**Сургууль**

**4** сургууль **3200** суудал

**Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор**

**7**

**Монгол өв уламжлал, ёс заншлийн өргөө**

**11** өргөө **1,100** ор

# АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ

**Зарцуулах дүн**

**177.5** тэрбум төгрөг хүртэл

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулна.



# Улаанбаатар бонд

Зарцуулалт болон үр дүн

БиДиСЕК ХК

**АГААРЫН БОХИРДЛЫН ХЭМЖЭЭГЭЭР**

| Монгол Улс | Улаанбаатар хот |
|---|---|
| Дэлхийд **26-д** | Дэлхийд **464-т** |
| *Эх сурвалж: IQAIR** | *Эх сурвалж: IQAIR** |

**ТООСОНЦОРЫН БОХИРДЛЫН ХЭМЖЭЭГЭЭР**

Тоосонцорын хэмжээ

Аюулгүйн түвшнээс **27** дахин их

*Эх сурвалж: НҮБ*

**ТӨСЛИЙН ҮР ДҮН**

Тоосонцор
**72.6%**-иар буурна

Азотын исэл
**23.5%**-иар буурна

Хүхэрлэг хий
**85.5%**-иар буурна

Угаарын хий
**10.8%**-иар буурна

*Швейцарын агаар цэвэршүүлэгч үйлдвэрлэгч IQAir компани



# ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ

## Зарцуулах дүн

**72.5** тэрбум төгрөг хүртэл

Нийслэлийн инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулна.

# Улаанбаатар бонд

Зарцуулалт болон үр дүн

БиДиСЕК ХК

**УЛААНБААТАР ХОТЫН АВТО ТЭЭВРИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Замын урт

**1,185 км**

*Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар*

Улаанбаатар хот

Нийт замын **78%** түгжрээтэй

*2021 оны байдлаар*

**ТӨСЛИЙН ҮР ДҮН**

- Үйлдвэрлэл технологийн парк барьснаар Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, Налайх, Багануур дүүргийн эдийн засгийг сайжруулахаас гадна тухайн бүс нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх давуу талыг бий болгоно.
- Нэг чигийн хөдөлгөөний урсгалтай үерийн сувгийн далангийн 2 талаар зорчих хэсэг, ногоон байгууламж, явган хүний зам бүхий Энхтайваны өргөн чөлөөнөөс урагш Нарны замыг холбосноор Энхтайвны өргөн чөлөө, Нарны зам, зүүн 4 замын уулзварын хөдөлгөөний ачааллыг хуваарилах ач холбогдолтой байна.
- Дотоодын барилгын материал үйлдвэрлэл 1.8 дахин нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн төрөлжсөн барилгын материалын үйлдвэрийн бүс бий болгоно.

## ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Нийслэлийн гаргах үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төсөвт тусгагдсан байх ба тухайн Нийслэлийн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах хөрөнгийн удирдлага нь дараах процессын дагуу гүйцэтгэнэ.

1. Нийслэлийн Засаг дарга: Жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 сарын 25-ны дотор НИТХ-д өргөн мэдүүлнэ.
2. НИТХ: Жилийн төсвийн төслийг 12 сарын 05-ны дотор батална.
3. Нийслэлийн Засаг дарга: Батлагдсан төсвийг 12 сарын 31-ний дотор Сангийн яам-нд хүргүүлнэ.
4. Сангийн яам: Нэгдсэн төсөв хуваарилна.
5. НЗДТГ-ын ХБТХ: Нийслэлийн Засаг даргын захирамж боловсруулж, батлуулна.
6. НЗДТГ-ын ХБТХ: Батлагдсан захирамжийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.
7. Холбогдох байгууллага*: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хяналт тавих
8. НЗДТГ-ын ХБТХ-ээс төлбөр шилжүүлэх эрх нээж, СТСХ-ээс гүйлгээ хийнэ.

**Холбогдох байгууллагууд гэдэг нь Захиалагчийн хяналт тавих байгууллагуудыг хэлнэ.*

## ТАЙЛАГНАЛ

Төсвийн тухай хуулийн 7.4-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнадаг. Бондын санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээний хяналт, тайлагналыг Засгийн газрын 2020 оны 206-р тогтоол болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам, Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, журмыг үндэслэн хяналт, тайлан мэдээг хүргэж ажиллана.

1. Захиалагчийн хяналт тавих байгууллагууд нь арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн явцын мэдээний тайланг 14 хоног тутам Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст танилцуулна.
2. Нийслэлийн Засаг дарга
   Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, Сангийн яам-нд улирал бүр тайлагнана.
3. Нийслэлийн Засаг дарга
   Хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг Сангийн яам-нд хүргүүл
4. Нийслэлийн Засаг дарга
   Жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор Сангийн яаманд хүргүүлэх
5. Улирал, жил тутам татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг СЗХ-нд хүргүүлнэ.
   Санхүүгийн зохицуулах хороо татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана.
6. Бондын зарцуулалт, төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Монголын хөрөнгийн биржийн вэб сайтаар дамжуулан ил тод мэдээлнэ.

*1: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам*
*2-4: Төсвийн тухай хууль*
*5: СЗХ-ны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам*

# Улаанбаатар бонд

Тогтвортой хөгжлийн зорилгод нийцэж буй байдал

БиДиСЕК ХК




## Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилт 4.2
2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг бага боловсролд бэлтгэж бага насны хүүхдүүдийг хөгжүүлэх чанартай үйлчилгээ, тусламж, сургуулийн өмнөх боловсролоор хангах

## Түгжрэлийг бууруулах

Зорилт 9.1
Хүн бүрт тэгш, хүртээмжтэй байх талыг голлон анхаарч эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц, түүний бүсийн болон хил дамнасан дэд бүтцийг хөгжүүлэх

## Агаарын бохирдлыг бууруулах

Зорилт 11.6
2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах

**Би Ди Сек ҮЦК**
Mongolia's Largest Broker

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

CONTACT
Address

БиДиСек ХК,
Залуучуудын өргөн чөлөө 27/1,
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот Монгол улс

BDSec Securities